

# ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТАСАГ НЬ НАСАНД ХҮРЭГСЭДИЙН

## ДОТОР, МЭДРЭЛ, МЭС ЗАСЛЫН



### 7/24 ЦАГИЙН ТУРШ

### ХАРЬЯАЛАЛ

### ХАРГАЛЗАЛГҮЙ ҮЙЛЧИЛЖ БАЙНА.

ЧИГЛЭЛЭЭР


Хаяг: 13270 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн

Цагийн хуваарь: Даваа-Баасан 8:20-16:20  
Бямба, Ням амарна

Вэбсайт: [www.mjhospital.mn](http://www.mjhospital.mn)

Утас: 7700-2528

[Facebook.com/mjhusa.edu.mn](https://www.facebook.com/mjhusa.edu.mn)



## МОНГОЛ-ЯПОН ЭМНЭЛЭГ

Акагаахын Шэнжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

1942

# РАДИОЛОГИЙН ТАСАГ

- Соронзон үелзүүрт томографи (MRI)
- Компьютерт томографи (СТ)
- Дижитал рентген (X-RAY)



№ .....  
Овог, нэр: .....  
Нас: .....  
Огноо: .....

АШУУИС-ийн Монгол Япон эмнэлэг нь Япон Улсын Засгийн Газрын буцалтгүй тусламжаар үүссэн байгуулагдаж 2019 оны 6 сард үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба Монгол Улсын анхны Их сургуулийн эмнэлгийн тогтолцоог бүрдүүлсэн эмнэлэг юм.

#### БИДНИЙ ДАВУУ ТАЛ:

- ✓ Аюулгүй, тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээ
- ✓ Эрдэмтэн, профессор, чадварлаг эмнэлгийн мэргэжилтэн
- ✓ Оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологи
- ✓ Эмнэл зүй, сургалт, судалгааг хослуулсан Их сургуулийн эмнэлгийн тогтолцоо
- ✓ Япон менежмент
- ✓ Олон улсын стандартад нийцсэн эмнэлгийн зориулалттай барилга, байгууламж
- ✓ Барилга байгууламжийн бүрэн автомат бүхий 12 дэд системтэй.

#### РАДИОЛОГИЙН ТАСАГ

##### Компьютерт томографи шинжилгээ

Компьютерт Томографийн / КТГ / шинжилгээ нь шинжлүүлэгчид ямар нэг зовиургүйгээр өвчин эмгэгийг нарийн тодорхойлох орчин үеийн оношилгооны хамгийн шилдэг арга юм. Манай оношилгооны төв TOSHIBA Брендийн AQUILION PRIME загварын нэг эргэлтээр 0,5 мм нимгэн 160 зүслэг хийх 360 детектерийн хүчин чадалтай Компьютерт Томографийн / КТГ / аппарат юм.

КТГ шинжилгээ нь рентген туяаг хүний биеэр нэвтрүүлж эрхтний бүтцийг өндөр нарийвчлалтай дүрсэлдэг оношилгооны шилдэг арга юм.



#### ТӨХӨӨРӨМЖИЙН ДАВУУ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ

- Монголд хамгийн олон буюу 160 зүслэгтэй.
- Хамгийн өндөр нарийвчлалтай ба 3D хэмжээст зураг боловсруулах чадвартай.
- Цацраг идэвхт туяа ялгаруулалтыг 75%-иар бууруулсан.
- Хүний биед үзүүлэх рентген туяаны тунг багасгаж, оношилгооны чанарыг сайжруулсан.
- Зүрхний дараах өвчлөлийг оношилно. Үүнд:
  - Зүрхний титэм судасны бөглөрөл
  - Зүрх судасны шохойжилт
  - Зүрхний алших чадвар
  - Ангиографийн зураг авах
- Уушгины хорт хавдрыг бага цацрагаар эрт илрүүлэх боломжтой.
- Хүүхдэд өгөх цацраг идэвхт туяаг тохируулах программтай.
- Металл суулгэцн сарнилыг багасгах нэмэлт программтай.
- 1 секундэд 60 зураг боловсруулах хурдтай.
- Эрхтний эзэлхүүн тодорхойлно.
- Яс болон судсыг ялган оношлох SEMAR нэмэлт программтай.
- Хүнд өвчтөн, илүүдэл жинтэй, тэргэнцэртэй хүмүүс үйлчлүүлэхэд илүү тохиромжтой.
- Тархи толгой, хүзүү, цээжний хөндийн, хэвлийн хөндийн, аарцгийн хөндийн, эмгэгтэйчүүд, бөөр шээсний зам, яс булчинд хавдар байгаа эсэх, хэрэв хавдар илэрвэл түүний байрлал, хэмжээ, бусад эрхтэнд нэвчсэн байдал, үсэрхийлэл, үе шатыг тодорхойлно.
- Судасны 3 хэмжээст зураглал боловсруулна.
- Цэс, бөөр, давсагны чулуу, хавдрын туяа эмчилгээ, хими эмчилгээний дараах үр дүнг хянах ач холбогдолтой.


#### КОМПЬЮТЕРТ ТОМОГРАФИЙН / КТГ / ТОДОСГОГЧ

Тодосгогч бодис иод агуулсан бөгөөд туйлын эсрэг заалт байхгүй бөгөөд дараах тохиолдолд эмчийн заалтаар болгоомжтой хэрэглэнэ. Үүнд:

- Хат мэдрэг ялангуяа зүрх судасны хүнд өвчтэй
- Шингэн алдалт
- Бөөрний үйл ажиллагааны дутмалшил
- Өндөр настан
- Бамбай булчирхайн өөрчлөлттэй
- ТМТ-ны эмгэгүүд
- Архины хордлого
- Феохромотоз
- Аутоиммуну эмгэг
- Миастени

#### Тодосгогч хэрэглэхийн ач холбогдол:

- Хорт, хоргүй хавдрыг ялган оношилгоо хийнэ.
- Судасны эмгэгүүдийг ялган оношилно
- Шээс ялгаруулах замд саатал байгаа эсэх, саатлын түвшинг тодорхойлно.



#### Шинжилгээнд хэрхэн бэлтгэх вэ?

- + 8-12 цаг юм идэж, уугаагүй байна.
- + Давсаг бага аарцгийн эрхтэнүүдийг оношуулах үүдэвс дүүрэн шээстэй байна.
- + Хүнд, маш хүнд өвчтөнийг оношуулахад эмчлэгч сувилагч эмч нар дагалдан ирнэ.
- + Хэвлийн хөндийн Компьютерт Томографийн / КТГ / шинжилгээний үед 200-300 мл шингэн үулгаж хэрэглэнэ.
- + Хэрэв судсаар тодосгогч бодистой шинжилгээнд орох тохиолдолд 15-20 минутын өмнө сорил хийнэ.
- + Харшлын урвал илэрвэл шинжилгээ хийх боломжгүй болно.
- + Тодосгогч бодистой шинжилгээ хийлгэхийн өмнө үйлчлүүлэгчээс бичгээр зөвшөөрөл авч шинжилгээ журамтай танилцуулж, зөвлөгөө өгнө.
- + Шинжилгээний төрлөөс хамаарч шулуун гэдсээр эзгүйдэл үулгах хэлбэрээр тодосгогч бодисыг хэрэглэж болно.

#### MRI, CT шинжилгээний DVD үнших заавар:

Шаардагдах программ: **Radiant DICOM viewer** программыг татаж авч суулгана. **Radiant DICOM viewer** программыг нээн зүүн дээд булан дээр байрлах **Open DICOM CD/DVD** товчлуурыг даран DVD дээр байгаа зүргүүдийг ачааллуулна. Олон зурагтай шинжилгээг үншихэд 10-аад минут шаардагдана гэдгийг анхаараарай